



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

07.	Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	43
08.	Шүүхийн захиргааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	44
09.	Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	45
10.	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	46
11.	Архивын тухай хуульд өөрчлөлт оруюлах тухай	47
12.	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	47
13.	Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	48
14.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	48
15.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	48

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

16.	“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 67	49
-----	--	-----------	----



17.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай	Дугаар 70	50
18.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 71	50
19.	Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилох, чөлөөлөх тухай	Дугаар 72	51
20.	Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 73	51
21.	Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай	Дугаар 74	52
22.	Зарим Байнгын хорооны дарга нарыг чөлөөлөх тухай	Дугаар 75	53
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
23.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох тухай	Дугаар 206	53
24.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 209	54
25.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 210	54
26.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлж, шилжүүлэн томилох тухай	Дугаар 211	55
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
27.	Олон улсын байгууллагад гишүүнээр элсэх тухай	Дугаар 363	55



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.1.1¹ дэх заалт:

“6.1.1¹.агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих чиг үүрэг бүхий Үндэсний хороо байгуулж ажиллуулах;”

2/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:

“6.2.Энэ хуулийн 6.1.1¹-д заасан Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхий сайд батална.”

3/6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг:

“6.3.Энэ хуулийн 6.1.1¹-д заасан Үндэсний хороо нь ажлын албатай байх бөгөөд уг ажлын алба нь байнгын цахим мэдээллийн сүлжээг ажиллуулж, иргэд мэдээлэл тогтмол авах боломжийг хангана.”

4/6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг:

“6.4.Энэ хуулийн 6.3-т заасан ажлын албаны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.”

2 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 5 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн захиргааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “Ерөнхий зөвлөл нь” гэсний дараа “энэ хуулийн 3.2-т зааснаас гадна” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “авах” гэсний дараа “, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хамгаалах” гэж, 7.1.7 дахь заалтын “журмыг” гэсний дараа “хуульд заасны дагуу” гэж, мөн зүйлийн 7.1.21.г дэх дэд заалтын “загварыг” гэсний дараа “хуульд заасан журмын дагуу” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “үнэлэх,” гэсний дараа “шалгаруулах,” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “хуралдаан” гэсний дараа “/цаашид “Хуралдаан” гэх/” гэж, 19 дүгээр зүйлийн гарчгийн “чөлөөлөх” гэсний дараа “, огцруулах” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Шүүхийн захиргааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “Ерөнхий зөвлөл” гэснийг “Шүүхийн ерөнхий зөвлөл /цаашид “Ерөнхий зөвлөл” гэх/” гэж, 5 дугаар зүйлийн гарчгийн “бүрэн эрх” гэснийг “чиг үүрэг” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1, 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтын “Шүүхийн ерөнхий” гэснийг “Ерөнхий” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын “тогтоож” гэснийг “тогтоох” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтын “захиргааны ажилтнуудын” гэснийг “тамгын газрын даргын” гэж, 7.1.7 дахь заалтын “дуу болон” гэснийг “дуу авиа,” гэж, 7.1.8 дахь заалтын “лавлагаа, удирдамжаар” гэснийг “лавлагаагаар” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “тавигдах” гэснийг “тавих болзол,” гэж, 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “Ерөнхий зөвлөлийн хуралдааныг” гэснийг “Хуралдааныг” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “эрхэдээ” гэснийг “эрхэд” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын “нэрсийн жагсаалтыг гаргах, бүртгэх, тэдгээрийг”, “тэдгээрийн аюулгүй байдлыг хангах,” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “зөвлөлийн” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.2.9 дэх заалтын “болон бусад хураамж” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Шүүхийн захиргааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



5 дугаар зүйл.Энэ хуулийг 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 11.2.9 дэх заалт:

“11.2.9.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбар.”

2/24 дүгээр зүйлийн 24.6-24.10 дахь хэсэг:

“24.6.Тавин таван насанд хүрсэн шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэврээ тогтоолгож болно.

24.7.Шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэврээ тогтоолгож болно.

24.8.Хуульд заасан нас, болзлын дагуу өндөр насны тэтгэвэрт гарсан шүүгчид сүүлийн нэг жилийн цалингийн дунджаар тооцон 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.

24.9.Шүүгчийн тэтгэвэртэй холбоотой бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

24.10.Шүүгчийн ээлжийн амралтын үндсэн хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоох бөгөөд шүүгчээр ажилласан таван жил тутамд ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт олгоно.”

2 дугаар зүйл.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийн “зөвлөл” гэсний дараа “Шүүхийн мэргэшлийн



хороотой хамтран” гэж, 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгийн “гишүүдэд” гэсний дараа “Шүүхийн мэргэшлийн хорооны ажлын алба” гэж, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн “Шүүхийн ерөнхий зөвлөл” гэсний дараа “Хуульчдын холбоотой хамтран” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “4, 5 дугаар” гэснийг “4 дүгээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.4.6 дахь заалтын “эрх зүйн онцгой байдалд” гэснийг “эрх зүйн байдлын онцлогт” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “хуулийн хариуцлага” гэснийг “хуульд заасны дагуу хариуцлага” гэж, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “сэлтийг” гэснийг “, дурсгалын зүйлийг” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.6-23.10 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

АРХИВЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Архивын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч” гэснийг “Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “Уулзалт зохион байгуулахад өмгөөлөгчийн эрхийн үнэмлэх болон аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн олгосон томилолтыг үндэслэх бөгөөд уулзалтын тоо болон хугацааг хязгаарлахгүй.” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нотариатын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн



“Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 180 хоногийн дотор” гэснийг “2014 оны 4 дүгээр сарын 15-ны дотор” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар
хот

**“Төрийн захиргааны байгууллагын
тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг
батлах тухай” тогтоолын хавсралтад
нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “9¹.Тахарын ерөнхий газар” гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Дээд шүүхээс санал болгосноор Дамдинсүрэнгийн Солонго, Шарын Цогтоо нарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Банзрагчийн Пүрэвням, Цэрэнбалтавын Сарантуяа нарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилох, чөлөөлөх тухай

Хяналтын зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн даргаар Равсалын Ринчинбазар, гишүүнээр Батболдын Амарсанаа, Дүгэрээгийн Цэрэнбадам, Агваандоржийн Өнөржаргал, Жадамбаагийн Эрдэнэбилэг нарыг тус тус томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажлаас Галбадрахын Даваажаргалыг, гишүүний үүрэгт ажлаас Дамдинсүрэнгийн Цэцэгмаа, Бямбажавын Ганбат, Гомбодоржийн Цэцгээ нарыг тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар
хот

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Батхүүгийн Гарамгайбаатар, Ёндонгийн Отгонбаяр, Цэрэндашийн Цолмон нарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн



Цэрэндашийн Оюунбаатарыг Төсвийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Гантөмөрийн Уянгыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Гаваагийн Батхүү, Догсомын Батцогтыг Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Улсын Их Хурлын гишүүн Гаваагийн Батхүү, Нямтайширын Номтойбаяр, Цэрэндашийн Оюунбаатарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Цолмонг Төсвийн байнгын хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүүн Догсомын Батцогтыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатарыг Өргөдлийн байнгын хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүүн Батхүүгийн Гарамгайбаатар, Гантөмөрийн Уянга нарыг Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар
хот

Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Оюунбаатар, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Гарьдхүүгийн Баярсайхан, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Догсомын Батцогт, Өргөдлийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Раднаагийн Бурмаа, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Агыпарын Бакей, Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Шаравдоржийн Түвдэндорж, Эдийн



засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Батхүүгийн Гарамгайбаатар нарыг тус тус сонгосугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар
хот

**Зарим Байнгын хорооны дарга
нарыг чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Цолмонг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргын, Улсын Их Хурлын гишүүн Зангадын Баянсэлэнгийг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 12 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар
хот

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн
гишүүнээр томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Базарсүрэнгийн Сарантуяаг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 209

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.3.1, 18.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Намсрайн Түвшинжаргалыг Төв аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас, өөрөө хүсэлт гаргасан тул Гарамжавын Буянжаргалыг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 210

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 18.7 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр настны тэтгэвэр авах насанд хүрсэн тул Түмээгийн Гариймааг Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгчийн, Дашдаваагийн Чулуунхүүг дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Санжаагийн Жамсранг дүүргийн



Эрүүгийн хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн шүүгчийн, Дугажийн Дамдиндоржийг Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн шүүгчийн, Ёндонгийн Ринзааныг Сум дундын 23 дугаар шүүхийн шүүгчийн, Бадамын Цагцалмаа, Мягмарын Пагма-Оролмаа нарыг Сум дундын 24 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 211

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлж, шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Шүүхийн өөр албан тушаалд шилжүүлэн томилж байгаатай холбогдуулан Дүйсенбекийн Көбөшийг Сум дундын 5 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Дүйсенбекийн Көбөшийг Сум дундын 25 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 11 дүгээр
сарын 2-ны өдөр

Дугаар 363

Улаанбаатар
хот

Олон улсын байгууллагад гишүүнээр элсэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Дэлхийн ур чадвар олон улсын байгууллага” (World Skills International)-д гишүүнээр элсэхийг дэмжсүгэй.



2. “Олон улсын байгууллага, гэрээ, конвенцийн итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай” Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 60 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Татварыг нь улсын төсвөөс төлөх олон улсын байгууллагуудын жагсаалт”-д дор дурдсан агуулга бүхий 69 дэх заалт нэмсүгэй:

“69. Дэлхийн ур чадварын Олон Улсын байгууллага-ХЯ”.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Я.САНЖМЯТАВ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 14003